

МОНГОЛЧУУД АЛТАН УЛСЫГ БАЙЛДАН ДАГУУЛСАН ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

А. Дашдэмбэрэл
Б. Даваасүрэн

Чингис хаан Их Монгол улсыг байгуулсны дараа гадаад улс орнууд руу хийсэн аян дайны дотроос Алтан улстай хийсэн дайн хамгийн олон жил үргэлжилсэн юм.

1211 оноос эхлэн 23 жилийн турш тасралтгүй дайтахад Чингис болон түүний залгамжлагчдын тухайлбал Чингис хааны хүүхдүүд, өрлөг жанжин го ван Мухулай түүний үр ач нар энэ дайныг удирдаж байв.

Алтан улсыг эзлэн авах энэ урт удаан хугацааны дайныг 4 үндсэн үе болгон хувааж үзэж болох юм. Үүнд:

Нэгдүгээр үе: 1206—1211 он. Энэ үе бол Алтан улсын эсрэг явуулах дайны бэлтгэлийг хангасан үе. Цэрэг-эдийн засгийн боломж сайтар суурьшмал орныг эзлэн авахын тулд маш их бэлтгэл хэрэгтэй байжээ. Чингис хаан юуны өмнө Алтан улсын доторх байдал, ард түмний сэтгэл санааны байдал, цэрэг-эдийн засгийн нөөц бололцоог зайлшгүй мэдэх хэрэгтэй байжээ. Чингис хаан дундад Азийн худалдаачид, дипломат элч нар Цагаан хэрмийн араар нутаглах Онгуд аймгийг ашиглан тагнуул зохион байгуулж бэлтгэл ажлаа хангажээ.

Хоёрдугаар үе нь: 1211—1217 он буюу Чингис хаан өөрөө байлдааныг удирдсан үе, Чингис хаан их цэргийг удирдан байлдаан явуулснаар Алтан улсын цэргийн хүч чадал, зэвсэглэл, байлдах эрдмийг сайн мэдэж авсны дараа байлдааны ажиллагаагаа эхэлжээ.

Гуравдугаар үе нь: 1217—1223 он хүртэл улсын ван Мухулайн байлдааныг гардан удирдаж явуулсан үе.

Дөрөвдүгээр үе нь: 1223—1234 он хүртэл буюу Өгэдэй болон Мухулайн ураг удмынханы дайлсан үе гэж үзэж болох байна.

Байлдааны үйл ажиллагааг ингэж үечлэн хуваахдаа дайны үйл ажиллагааг хэн удирдав гэдгээр гол болгон үзсэн боловч үе бүрийн байлдааны арга, тактикийн хувьд өөрийн өвөрмөц онцлогтой байна. Гэхдээ энэ дайн байлдаан нь Чингисийн цэргийн урлагийн үргэлжлэл бөгөөд түүний гэрээслэлийг нарийн чанд сахин биелүүлсний үр дүн билээ.

Чингис хаан болон түүний залгамжлагчдын Алтан улсыг эзлэхийн төлөө олон арван жилийн турш тасралтгүй байлдсаны шалтгаан нь:

1. Монголын олон хаадыг татаруудад дамжуулан Алтан улсад аваачин хороож байсан өвгөд дээдсийн олон үеийн өшөө хонзон.

2. Чингис хаан 1206 онд Их Монгол Улс байгуулснаа албан ёсоор мэдэгдэхэд урьдын хүчирхэг байдлаа хадгалахыг

* А. Дашдэмбэрэл. — Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

Б. Даваасүрэн. БХЯ-ны Цэргийн түүхийн институтын эрдэмтэн, нарийн бичгийн дарга' дэд доктор

хичээн шинэ хаан, шинэ улсыг хүлээн зөвшөөрөхгүй дорд үзэж ихэмсэглэн харьцаж байсан явдал.

3. Тухайн үед олон жилийн түүхтэй төв болон зүүн хойд Азид ихээхэн хүчирхэгжиж, нэлээд өндөр хөгжсөн улс зэрэгцэн орших нь шинэ тутам улсад дайсагнах нь мэдээж байв.

Чингис Алтан улсыг байлдах бэлтгэлээ хийж гүйцээд 1211 оны 2 дугаар сард сая Хэрлэний Их ордоноосоо морджээ. Алтан улс руу хөдөлсөн их цэргийг Чингис хаан ерөнхийд нь удирдан Зүч, Цагаадай, Өгөдэй, Толуй дөрвөн хүүдээ цэрэг удирдуулан, Зэв, Мухулай нараар манлай цэргийг удирдуулан явжээ. Ингэж хөдөлсөн Чингисийн их цэргийн байлдааны журам нь Монголын нууц товчоо болон бусад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн шиг байсан бололтой.

Зэв, Мухулай нарын цэрэг манлай болж явсны дараа Чингисийн хөвгүүдийн удирдсан цэрэг зүүн ба баруун гар болж, хаан өөрөө их гол цэргээ авч явжээ. Мэдээжээр өвс, ус муутай их говийг туулахад ар талын хангалтыг сайтар зохион байгуулж тусгайлан гаргасан цэрэг байсан байх ёстой. Энэ удаа дайнд явсан их цэргийн марш нь эрдэмтэн Сайшаалын бичсэнээр 180 уналгын газрыг (1 уналга газар нь 4 километртэй тэнцэнэ гэжээ) богино хугацаанд (1 сар орчим) туулан Цагаан хэрэмд тулж иржээ (4.696—697).

Чингис хаан эхний удаад Цагаан хэрмийн хойтох Чуулалт хаалга болон Бээжин хотыг хамгаалсан чухал бэхлэлтийн нэг болох чухал боомтуудыг эзлэн цэргээ 3 хэсэг болгон Хэбэй, Хэдун, Шандуны чиглэлээр олон хотуудыг эзлэн авч түр найрамдал байгуулан хойш эгсэн боловч тэр нь удаан үргэлжилсэнгүй 1214 онд дахин дайнд мордож Бээжин хотыг бүрмөсөн эзэлж Алтан улсын нийслэлийг Кайфинд шилжүүлснээр аян дайнаа зогсоож өөрийн итгэлт жанжин Мухулайд Алтан улстай хийх дайныг цаашид үргэлжлүүлэхийг даалгаад нутгийн зүг буцжээ.

Мухулай (1170—1223) Жалайрын Тэлэгэту баяны ач Гүн Гуаны гуравдугаар хөвгүүн билээ. Өвөг эцэг Тэлэгэту Баян нь 1197 онд Чингисийг Жүрхин нартай байлдаж Тэлэгэту амсар гэдэг газар буудаллаад байх үед нь үр ач нараа авчирч Чингис, Хасар нартай уулзуулан өгснөөс хойш Чингис хаанд хүчээ өгөн зүтгэж түүний итгэлт хүлэг баатруудын нэгэн болсон юм. (2.1)

Мухулай жанжин Чингис хааны зарлигийг хүлээж аваад Алтан улсыг дайлснаас хойш хэдхэн жилийн дотор хэтэрхий их хүч хэрэглэлгүйгээр Ляодун, Ляоси, Шандун Хэбэй зэрэг газруудыг эзлэн авчээ.

Мухулай жанжин морьт ба явган цэргийн байлдааны онцлогийг маш сайн мэддэг байлдааны тактикийг тухайн цагийн байдал болон газар орны онцлог нөхцөлөөс болж, өөрчлөн зохион байгуулж ялалтад хүрч байсан баримт олон бий.

Жининийг хоёр талаас морьт цэргээр довтолж дайран ялалт байгуулаад тэр эрчээрээ Гуанлинд довтолж оров. Энэ үед Алтан улсын цэрэг Хатан голын бэрх бартаат газар хоригдон байлдахаар бэлтгэсэн тул түүнийг үзээд Мухулай: «Үүнийг морьт цэргээр байлдаж болохгүй» гээд олон цэргээ мориноос буулган холхивч нумаар цэцэн харвахад Алтан улсын цэрэг их л днийлэгдэж олонх нь цөм Хатны голд живж үхжээ. (5.72). Мөн Алтан улсын Ян Аньфуг сахисан вангин Хода гурван түмэн цэ-

рэг авч Монголын цэргийг угтан байлдахаар гарч ирсэнд Мухулайн хошууч Монгол Буха гурван мянган морьт цэрэгтэй байдлыг ажиглан үзээд «Дайсан манай цэргийг цөөн хэмээн басаж байх тул бид бүгсэн цэргээр дийлж болно» гэж мэдүүлэв. Мухулай зөвшөөрч шөнийн гүнд хүний аманд тэмдэг мод үмхүүлж, морины хазаар дөрөөг бүсээр боогоод зэр зэвсэг харуулалгүй сэмээр мордон хотоос зүүн тийш 15 газар хол байгаа их олон өвстэй ганга гууд очиж бүгүүлэв. Маргааш нь Монгол Буха цэргээ авч мордоод Алтан улсын цэргийг үзмэгц туг хуур, хэнгэрэг хараангаа хөндлөн гулд хаяж буруулан зугаажээ. Алтан улсын цэрэг үнэхээр нэхэж ирсэнд бүгсэн цэрэг дөрвөн зүг найман зөвхисоос гарч ирээд тэнгэр газрыг донсолтол хэнгэрэг нижигнүүлэн аадар бороо цутгах мэт суман мөндөр буулгасанд Алтан улсын цэрэг их л ялагдаж долоон мянган гаруй хүнээ алдаад хотноо зугтаан орж үүд хаалгаа чанд дарж гарч ирэхгүй болсон байна. (5.74—75).

Дайсны тал их хүч бөөгнүүлэн тэр талын хүч цөөн болохыг урьдчилан мэдэж тооны олонд эрдэн бардсан шинжтэй байгааг тагнуулын мэдээгээр баттай мэдэж чадсан нөхцөлд цөөн хүчээр дайсныг арга мэхэндээ оруулан цэргийн нэлээд хэсгийг ямар ч дуу чимээ гаргахгүй бүгүүлэн цөөн хэсэг хүмүүсийг зориуд тэдэнд харагдуулан өөрсдөө айн ухарч зугтсан дүр үзүүлэн хуурч бүгсэн хүчин дээрээ оруулж, самгардуулан тал талаас нь зэрэг дайран бут цохих тактикийг хэрэглэж байжээ. Мөн хотыг таслан удаан хугацаагаар бүслэн хоол ундаар тасалдуулан буулгаж авах аргыг хэрэглэж байв.

Мухулай жанжин бол эзэлсэн хот тосгодынхоо хүн ардыг зэрлэгээр устгах, эд хогшлыг булаан дээрэмдэхийг хориглодог байв. Мухулай Ляодун, Ляо-си-г түвшитгээд Шанжингаас мордож Хэбэй мужид цэрэг оруулахдаа «Олон замын жанжин цэрэг ард иргэдийн хөрөнгийг өчүүхэн төдий ч хөдөлгөж болохгүй» (5.72) гэж зарлиг буулгаж байв. Тэр нэгэн жанжиндаа салаа цэрэг үлдээгээд «Дун Финий амд хүнс дуусвал лав хотоо хаяж явах болно. Чи тэднийг явсны сүүлээр даруй хотод орж төвхнүүлэн амаржуулсугай. Битгий ард иргэдийг түйвээн зовоож миний найдсан хэргийг үтгээрэгтүн» хэмээн тушааж байв (5.73). Монголын цэргүүд хот тосгоныг эзэлсний дараа эд баялгийг хоослон дээрэмдэхийг хориглон олзолсон настан хүүхдийг нутагт нь буцаадаг байсан. Гагцхүү эрчүүдийг цэрэгт дайчилж, эмс охидыг эхнэр, зарц болгодог байлаа (2.10).

Чингис хаан болон түүний залгамжлагчдын олонх нь ийм л бодлого баримталж байсныг зөвлөлтийн болон монголын зарим түүхчид хэтэрхий харгис талаас нь үнэлэлт дүгнэлт өгсөн байдаг. БНМАУ-ын түүхийн 3 боть зохиолын тэргүүн ботьд «Чингис хаан харь орныг байлдан дагуулах үеэрээ эзлэгдсэн ард түмний эсэргүүцэн босох хүчин чадлыг дуустал арилгах, энгийн номхон ард түмнийг айлган сүрдүүлэх зорилгоор аллага хядлагыг зориуд зохион байгуулалттайгаар явуулж байжээ. Чухамхүү үүгээрээ Чингисийн байлдан дагуулал нь түүний урьдах нүүдэлчин язгууртан нарын суурьшмал ард түмнийг уулгалан довтолж байсантай зүйрлэлшгүйгээр харгис дотшин шинж чанартай байжээ» (3.241) гэж дүгнэсэн нь хэтэрхий нэг талыг барьсан өрөөсгөл дүгнэлт болсон юм.

Мухулай цэргийн их үйлийг эрхэлж чадахгүй болсноо мэдээд дүү Тайсуныг цачирын өмнө дуудаж авчиргаад «Би улс гүрний төлөө хуяглан цэрэглэн дөчин жил зүүнш байлдаж баруунш дайлаад их үйлсийг туслан бүтээлээ. Гагцхүү Алтан улсын нийслэл хот Бяняныг эзлэн авч чадсангүйдээ хорсоно. Чи байлдан эзлэхээр хичээгтүгэй» гэж гэрээслээд нас баржээ.

Мухулайг нас барсны дараа түүний ахмад хүү Бохул эцгийнхээ зэрэг хэргэмийг залгамжлан авч Алтан улстай нэгдсэн улсын цэрэгтэй байлдаж гавъяа байгуулсан билээ. Чингис хааны нас барсны гашуудалд биеэр оролцож хэтэрхий гашуудсанаас өвчин олж цэл залуухан 32 настайдаа нас баржээ.

Бохулын 6 хүүгийн ахмад нь Тас буюу Чулуун байв. Тэрээр эрэлхэг баатар бөгөөд их бодлоготой, өвөг эцгийнхээ сурталтай хэмээн алдаршжээ. Тас 18 настайдаа эцгийнхээ зэрэг хэргэмийг залгамжлан 1229 оноос эхлэн 1234 он хүртэл Алтан улсын эсрэг байлдан Алтан улсыг эрхэндээ бүрэн оруулан буулгаж авсан мэдээг хамгийн түрүүнд Өгөдэй хаанд хүргэсэн билээ.

Мухулай жанжин болой түүний үр ач нар эзэн хаандаа үнэнч байж Монголын хамгийн заналт дайсан Алтан улсыг түвшитгэх олон жилийн аян дайнд оролцож гавъяа байгуулсан билээ.

Мухулай түүний үр удмынхан хэдийгээр эрэлхэг дайчин баатар эрчүүд байсан боловч эзлэгдсэн орны ард иргэдэд элэгсэг энэрэнгүй ханддаг байсан юм.

Монголын цэрэг Алтан улсыг олон жилийн турш тасралтгүй байлдаж байж эрхшээлдээ оруулж авсан тухай судалгааны бүтээлүүдэд тодорхой судалж дүгнэсэн байна.

Алтан улсын эхний томоохон ялагдал нь: 1. Тухайн Алтан улсын шинэ хаан нь цэргийг удирдан зохион байгуулах чадвар муу, бичиг цэргийн томоохон жанжин сайд нарынхаа үнэтэй зөвлөлгөөг хайхарч үздэггүй, дураараа хүн байснаас монголын цэрэгтэй байлдах бэлтгэлийг хангаж чадаагүй байсан.

2. Монголын цэрэг байлдааны бэлтгэлийг нэн эртнээс хийж цэргийн зохион байгуулалт, сахилга бат, байлдах чадвар нь асар өндөр хэмжээнд хүрсэн байв.

3. Монголын тал ойр зэргэлдээ улсуудыг талдаа бүрэн татаж тэдэнд туслах гаднын хүчгүй болгон ганцаардуулсан зэрэг үндсэн хэдэн шалтгаан байв.

Монголын нэгдсэн төр байгуулагдсанаас хойш Чингис хаан болон түүний залгамжлагчид богино хугацаанд ойр зэргэлдээ улс гүрнийг эзлэн талдаа бүтэн жил явах өргөн уудам нутгийг эрхшээлдээ оруулсан билээ. Өмнө зүгийн улсуудын дотроос Алтан улс олон жил Монголын цэргийн эсрэг тэмцсэн болохоор ихээхэн хүчтэй өрсөлдөгч нь байжээ. Тэдний хүч чадал нь юунд байв гэдгийг товч авч үзье.

1. Алтан улсын цэрэг томоохон хотуудад төвлөрч тэднийг маш бат бэх хэрэм, боомтуудаар хамгаалсны гадна хотоо тойруулан гүн өргөн гуу ухаж хамгаалалтыг сайн хийдэг байсан нь ихэвчлэн хөнгөн морьт цэргээр довтлон түргэн хугацаанд

* Бохулыг бидний олж үзсэнээр БИМАУ-ын түүхийн 3 ботийн тэргүүн ботьд Бор «Чингисийн есөн өрлөгт» Бохул, байлдааны үлгэрт Булу гэж бичсэн байна.

буулгаж авдаг монгол цэргийн байлдааны тактиктэй зөрчилдөж байв.

2. Монголчуудын хэрэм, хотыг эвдэж хэмхэлдэг зэвсгийн эсрэг хүчтэй зэвсгүүдийг түргэн хугацаанд бэлтгэн хэрэглэж ихээхэн хохирол учруулж байв.

3. Алтан улсын цэргийн жанжнуудын олох нь эзэн хаан болон улс орныхоо төлөө эцсийн дусал цусыг ч үл хайрлан тэмцдэг байв.

Алтан улсын цэргийн жанжин Хада ноён монголын эсрэг 20 гаруй жил тулалдаж аргагүйн эрхэнд Тулуй, Өгөдэйн цэрэгт бүслэгдэн дарагдаж өөрөө баривчлагдаад эцсийн гуйлт болгон Сүбээдэй баатартай уулзуулаад өгөөч гэсэн хүсэлтийг хүлээн авч уулзуулсны дараа өөрөө амиа хорлосон юм. Монголын цэрэгтэй эрэлхгээр тулалдан бууж өгөөгүй Алтан улсын цэргийн хошууч Чжэн Хэ шаныг Өгөөдэй хаан ихэд хайрлан өөрийгөө хорлосны дараа түүнийг хүндэтгэн «Сайн эр минь эргэж төрөхдөө монгол оронд минь очиж төртүгэй» хэмээн цацал өргөж байв.

Монголын цэрэг Алтан улсын Лин то фу хотыг байлдан авч хотын эзэн Хотумэнийг бариад түүнийг өршөөхийн тулд сөгд хэмээвээс үл сөгдөхийн тул цэргийн хүн уурлаад өвдгийг цавчихад Хотумэн үл боссоны тул түүнийг алжээ. Хотумэний гэргий Үгүлүн ши гэрийн хүндээ өгүүлрүүн: «Эр минь хааны нэрийг үл хугалан үхэв. Би эрийнхээ нэрийг юунд хугалах» хэмээгээд даруй боож үхэв.

Алтан улсын Айзун хаан амиа өгүүтгэн галд шатсаны дараа монголын цэрэг орж ирэхэд Алтаны нэгэн түшмэл хааныхаа шатаж дуусаагүй цогцосын дэргэд бүхнийг умартан гашуудан шатаж дуусахыг нь хүлээж байдаг. Та юунд их дайны хөлд ийм амирлангуй сууж байна гэхэд «Би хааныхаа шарилыг шатаж дуусахаар нь цуглуулан авч ёс төрийг гүйцэтгэн оршуулах гэсэн билээ. Энэ ёсыг гүйцэтгэсний дараа намайг алж болно» гээд ажиг ч үгүй сууж байсан юм (1, 87). Энэ мэт хаан төр улс эх орондоо үнэнч дайчин эрс олон байсны баримтууд тааралдана.

4. Алтан улсын хаад, түшмэл дайнд амжилт олохын тулд цэрэг дайчдыг шагнаж урамшуулах, тэднийг зоригжуулахын тулд ямагт дэргэд нь байж сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг байв.

Алтан улсын хамгийн сүүлчийн хаан Айзун Монголын болон Сүн улсын цэргийн хүчийг тогтоон барихын тулд цэргийн хуаран болон дайны талбараар явж тэдний дунд орж асгарсан борооны дундуур ч нөмрөггүй явж жанжин цэргүүдэд хэргэс зэрэг, хайр шагнал өгч байв. Тэр хаан цэрэг, ардад их элэгтэй, цомхон дөлгөөн, төлөв төвшин, ухаалаг хаан байсан боловч өөрийг нь төр барьж байх үед өвгөдийн тогтоон бэхжүүлж 100 илүү жил тогтносон төр нь эвдрэхэд хүрсэнд ихэд гутран гунхарч цэргээ оройлон удирдаж моринодоо мордож байлдах боломжгүй махлаг тарган биетэйн аргагүй учрыг хэлж Ван ян овгийн нэгэн том түшмэлдээ төрийн тамгаа шилжүүлэн өөрөө амиа өгүүтгэсэн билээ.

Чингис хааны цэргийн урлагийн хөгжилтөд Алтан улстай байлдсан байлдааны ажиллагаа томоохон сургууль болсон билээ. 23 жил үргэжилсэн байлдаанд Монголын олон цэргийн жанжин тодрон гарч суурьшмал орныг байлдан эзлэх байлдааны арга төлөвшин тогтож улмаар цаашид Европ, Азийн олон орны эсрэг амжилттай байлдахад цэргийн эрдэм, байлдааны аргад томоохон өөрчлөлт гарчээ.

Гэрч татсан ном, зохиол

1. Алтан улсын судар, Г. Бат-Очирын орчуулга, Гар бичмэл, 1930.
2. Б. Багана Есөн өрлөг 1984, Хайлар
3. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть, нэн эртнээс XVII зуун. УБ, 1966.
4. Сайшаал. Чингис хааны товчоон. II боть, Хөх хот, 1987.
5. Эртний Монголын байлдааны үлгэр, Хөх хот, 1988.